



ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАЛААР ГАРСАН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ, ТҮҮНД ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Г.Золжаргал

*Хууль сахиулахын их сургуулийн
магистрант*

Дэлхийн улс орнуудын түүхэнд 200 гаруй жилийн настай Захиргааны хэргийн шүүх нь захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, маргааныг хянан шийдвэрлэх, зөрчигдсөн эрхийг сэргээн тогтоох, захиргааны хууль бус үйл ажиллагаанаас хүний эрхийг хамгаалах зэрэг чиг үүргийг гүйцэтгэж байдаг. Энэ нь эцсийн дүнд шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг хангаснаар биелэлээ олдог. Шүүхийн мөн чанарыг илэрхийлэх гол шинж бол түүний шийдвэр хууль зүйн хүчин чадалтай байж, заавал биелэгдэж байхад оршино. Учир нь иргэн, хуулийн этгээдийн хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх нь шүүх эрх мэдлийн үндсэн чиг үүргийн нэг билээ.

*Захиргааны хэргийн шүүх нь захиргааны байгууллага, албан тушаалтнаас гаргасан хууль бус шийдвэр, үйл ажиллагааг хүчингүй болгож, эрхээ хамгаалуулахаар иргэд, хуулийн этгээдээс гаргасан гомдол, нэхэмжлэлийн үндсэн дээр захиргааны хэргийг хянан шийдвэрлэж, төрийн гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд хүний эрхийг хамгаалж, шүүхийн хяналтыг хэрэгжүүлдэг билээ. Захиргааны хэргийн шүүх нь Үндсэн хуулийн цэцийн дараа бий болсон шүүхийн тогтолцоон дахь шинэтгэлийн том алхам бөгөөд Үндсэн хуулиар тунхагласан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах баталгаа болсон. Монгол улсын Үндсэн хуулийн 48 дугаар зүйлийн 1-д; *Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр шүүхийг дагнан байгуулж болно* гэж зааснаар Улсын Их Хурал 2002 оны 12-р сарын 26-ны өдөр “Захиргааны хэргийн шүүх байгуулах тухай”, “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай” хууль баталж, 2004 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс Захиргааны хэргийн шүүх нь үйл ажиллагаагаа эхлэн явуулж ирсэн.*

Монгол Улсад Захиргааны хэргийн шүүхийг байгуулсан явдал нь эрх зүйт төрийн шинжийг агуулсан, иргэн, хуулийн этгээдийн эрх, эрх чөлөөг шүүхээр хамгаалахыг хуульчилсан чухал үйл явдал бөгөөд энэ ажлыг практик дээр хэрэгжүүлэх механизмыг бүрдүүлжээ. Захиргааны хэргийн шүүхийн зорилт бол иргэний зөрчигдсөн эрх, эрх чөлөөг хамгаалах, эрх зүйн дэг журам болон төрийн захиргааны ба орон нутгийн захиргааны байгууллага үйл ажиллагаагаа хууль ёсны дагуу үр ашигтай явуулах нөхцлийг хангахад оршино.

ЗХХШТХ-ийн 70 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар ЗХШ-ээс гарах шийдвэрийг:

1.Маргаан бүхий захиргааны акт хууль бус болох нь тогтоогдвол түүнийг



хүчингүй болгосон,

2.Эрх зүйн харилцаа байгаа эсэхийг тогтоож хүлээн зөвшөөрсөн,

3.Захиргааны байгууллагаас гаргасан акт нь илт хүчин төгөлдөр бус болохыг хүлээн зөвшөөрсөн,

4.Захиргааны актыг гаргахгүй байгаа явдал болон эс үйлдэхүй нь хууль бус гэж тогтоогдсон бол шаардагдах захиргааны актыг гаргахыг тухайн захиргааны байгууллага, албан тушаалтанд даалгасан,

5.Төлбөр тогтоосон захиргааны актын төлбөрийн хэмжээг багасгасан,

6.Захиргааны байгууллага, албан тушаалтнаас иргэнд учруулсан хохирлыг гаргуулах, хохирлын хэмжээг өөрчилсөн, хассан,

7.Хэргийн нөхцөл байдлыг цаашид тодруулах шаардлагтай гэж үзвэл захиргааны байгууллага, албан тушаалтнаас дахин шинэ акт гартал захиргааны уг актыг түдгэлзүүлсэн,

8.Нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж, үлдсэнийг хэрэгсэхгүй болгосон,

9.Нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон зэрэг агуулгатай байж болно.³²

Захиргааны хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааг өнөөгийн байдлаар Монгол Улсад үйлчилж буй хууль тогтоомжийн байдлаар нь авч үзвэл:

Үндсэн хуулийн хүрээнд

Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 8-р зүйлд "... эрх нь зөрчигдвөл хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ бүрэн сэргээн тогтоолгох эрхтэй" гэж заажээ.

Мөн 1992 оны Монгол Улсын Үндсэн хуульд Монгол улсын иргэн төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй гэж заасан бөгөөд төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй³³ байхаар хуульчилсан байна. Түүнчлэн "хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө төр хариуцна"³⁴ гэж заасан нь Төрийн байгууллага, тэр дундаа төрийн захиргааны байгууллага, албан тушаалтнаас иргэдийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхолыг хөндөхгүй байх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцахаар заасан байна.

Иргэн захиргааны байгууллага, албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулах, хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд гомдлоо гаргах эрх³⁵ нь Үндсэн хуулиар мөн олгогджээ.

³² Захиргааны хэргийн мэдэгдэхүүн. УБ хот. 2004 он. 151 дэх тал.

³³ Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 12

³⁴ Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1

³⁵ Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14



Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т “захиргааны хэргийн шүүхийн хүчин төгөлдөр актыг Монгол улсын нутаг дэвсгэрт байгаа холбогдох бүх байгууллага, албан тушаалтан, иргэн заавал биелүүлнэ”, 78 дугаар зүйлийн 78.1-д “хэргийн оролцогчид захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн биелүүлэх үүрэгтэй” гэж зааж, шүүхийн шийдвэрийг захиргааны байгууллага, албан тушаалтан хэрхэн биелүүлэх арга, журмыг “хуулиар шууд биш”, хуульд заасан эрхийнхээ дагуу шүүх “шийдвэртээ” тодорхойлж болохоор³⁶ тусгасан байна.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг захиргааны байгууллага, албан тушаалтан сайн дураар биелүүлээгүй бол Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 183-188-р зүйл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу албадан биелүүлэхээр хуульд заасан байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 183 дугаар зүйлийн 183.1-д “Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх үндэслэл нь шүүхийн шийдвэр...ийн үндсэн дээр олгогдсон гүйцэтгэх хуудас байна.”, 185 дугаар зүйлд **төлбөр авагч** шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэхээр хүсэлт гаргасан, шийдвэрийг даруй биелүүлэх шаардлагатай гэж шүүгч үзсэн тохиолдолд гүйцэтгэх хуудас бичиж, шүүгчийн захирамж гарснаас хойш 7 хоногийн дотор уг захирамж, шүүхийн шийдвэр, шаардлагатай бусад материалыг хавсарган шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд хүргүүлэхээр заажээ. 186 дугаар зүйлд шүүхийн шийдвэр болон гүйцэтгэх хуудсыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд шууд хүргүүлэх нөхцөлийг, 187 дугаар зүйлд гүйцэтгэх хуудаст тусгагдсан байвал зохих зүйлүүдийг тус тус зааж өгчээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн хүрээнд

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үндэслэл нь иргэний болон **захиргааны хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр**, эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийтгэх тогтоол, хуульд заасан тохиолдолд бусад байгууллагын шүүхээр баталгаажуулсан шийдвэр байна” гэж зааснаас үзвэл захиргааны шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэх ажиллагаа иргэний шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаатай нэгэн адил зарчмаар явагдахаар зааж өгсөнөөс өөр захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрхэн явуулах талаар нарийвчилсан хуулийн зохицуулалт байхгүй байна.

³⁶ ЗХХШТХ-ийн 78 дугаар зүйлийн 78.2



Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхээс гарсан шийдвэрийн талаар:

Нийслэлийн Захиргааны хэргийн шүүх 2004 онд 40 хэргээс 22 хэрэг буюу 55 хувийг, 2005 онд 157 хэргээс 88 хэрэг буюу 56 хувийг, 2006 онд 199 хэргээс 111 хэрэг буюу 56 хувийг, 2007 онд 325 хэргээс 160 хэрэг буюу 49.2 хувийг, 2008 онд 364 хэргээс 158 хэрэг буюу 43.4 хувийг 2009 онд 450 хэргээс 138 хэрэг буюу 30.6 хувийг 2010 онд 532 хэргээс 203 хэрэг буюу 38.1 хувийг нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг болон бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн байна.

2004-2010 онуудад Нийслэлийн Захиргааны хэргийн шүүх 2067 хэрэг шийдвэрлэсэнээс 880 хэрэг буюу 43 хувьд нь нэхэмжлэгч иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг сэргээн шийдвэрлэсэн байна. **Зураг 1**



Эдгээр хууль бус шийдвэр, үйл ажиллагаа нь дийлэнхидээ ямар эрх зүйн харилцаанаас үүдэн гарсаныг авч үзвэл:

- Газрын маргаан 191
- Татварын маргаан 164
- Төрийн албан хаагчийг ажлаас халсан маргаан 132
- Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талаарх маргаан 131 байна.

Зураг 2






Дээрх тоон үзүүлэлтээс харахад Нийслэл болон дүүргийн Засаг дарга, газрын алба, татварын улсын байцаагч, төрийн албан тушаалтныг томилж чөлөөлөх эрх бүхий албан тушаалтан болох дүүргийн тамгын даргаас эхлээд сайд хүртэлх албан тушаалтнууд, ашигт малтмалын газрын геологи уул уурхайн кадастрын хэлтсийн дарга нараас гарсан **618** шийдвэр хууль бусаар гарсан байна.

Иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангасан **889** шүүхийн шийдвэрийг удирдлага болгосон заалтаар нь авч үзвэл:

1. Захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус шийдвэрийг хүчингүй болгосон – **518** шийдвэр ЗХХШТХ-ийн 70.2.1
2. Захиргааны байгууллага, албан тушаалтан - иргэн, хуулийн этгээдийн хооронд эрх зүйн харилцаа байгаа гэж үзсэн - **5** шийдвэр, ЗХХШТХ-ийн 70.2.2
3. Захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаа нь илт хүчин төгөлдөр бус болохыг хүлээн зөвшөөрсөн – **38** шийдвэр, ЗХХШТХ-ийн 70.2.3
4. Захиргааны байгууллага, албан тушаалтныг захиргааны шийдвэр гаргахыг даалгасан – **106** шийдвэр, ЗХХШТХ-ийн 70.2.4
5. Актын төлбөрийн хэмжээг багасгасан – **70** шийдвэр, ЗХХШТХ-ийн 70.2.5
6. Захиргааны байгууллага, албан тушаалтнаас иргэнд учруулсан хохирлыг гаргуулах, хохирлын хэмжээг өөрчилсөн, хассан – **4** шийдвэр, ЗХХШТХ-ийн 70.2.6
7. Захиргааны байгууллага, албан тушаалтнаас дахин шинэ акт гартал захиргааны уг актыг түдгэлзүүлсэн – **34** шийдвэр, ЗХХШТХ-ийн 70.2.7
8. Захиргааны байгууллага, албан тушаалтан нь иргэн, хуулийн этгээдийн гаргасан шаардлагыг хүлээн зөвшөөрсөн, эвлэрсэн – **105** шийдвэрийг тус тус эзэлж байна. ЗХХШТХ-ийн 42, 43

Зураг 3





Шүүхийн шийдвэр биелэгдэхгүй байгаа шалтгаан нөхцөлийн талаар:

Захиргааны хэргийн шүүхээс гаргасан шийдвэрийг хариуцагч сайн дураар биелүүлэхгүй, иргэнийг хохироосон үйлдэл үргэлжлэх тохиолдолд ИХШХШТХ-ийн 185-д зааснаар иргэн шүүхэд хандан “албадан биелүүлэх захирамж гаргуулах эсхүл гүйцэтгэх хуудас олгуулах”-аар хүсэлт гаргах эрхтэй байдаг. Үүний үндсэн дээр иргэд шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэх хүсэлт гаргасаны дагуу Нийслэлийн Захиргааны хэргийн шүүх 2004 онд **1** шийдвэрийг, 2005 онд **18** шийдвэрийг, 2006 онд **15** шийдвэрийг, 2007 онд шийдвэрийг **36**, 2008 онд **46** шийдвэрийг, 2009 онд **36** шийдвэрийг, 2010 онд **65** шийдвэрийг, нийт **217** шийдвэрийг өнгөрсөн хугацаанд албадан биелүүлүүлэхээр захирамж, шүүхийн гүйцэтгэх хуудас бичиж, Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанд хүргүүлжээ. **Зураг 4.**



Эдгээрээс өнөөдрийн байдлаар **54** шүүхийн шийдвэр биелэгдээгүй. Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанд ажиллагаа хийгдэж байна.

Эдгээр шийдвэрийн маргааны төрлийг авч үзвэл:

1. Газрын асуудлаар эрх бүхий албан тушаалтан захирамж, тушаал гаргахгүй, өргөдлийг шийдвэрлэхгүй байгаа - 22 маргаан
2. Төрийн албан хаагчийг ажилд эгүүлэн тогтоосон шийдвэр гаргахгүй, сонгон шалгарлуулалт зарлахгүй, ажилгүй байсан хугацааны цалин гаргаж өгөхгүй байгаа - 15 маргаан
3. Ашигт малтмалын лицензийг олгохгүй, өргөдлийг хүлээн авч шийдвэрлэхгүй, хугацааг сунгахгүй байгаа - 8 маргаан
4. Бусад маргаан 9 байна. **Зураг 5**



Шийдвэрийг биелүүлэхгүй байгаа албан тушаалтныг авч үзвэл:

1. Нийслэлийн Засаг дарга -18 шийдвэр,
2. Засгийн газрын болон яамны харьяа агентлагийн дарга нар -11 шийдвэр
3. Ашигт малтмалын газар, Геологи уул уурхайн кадастрын хэлтсийн дарга- 8 шийдвэр
4. Дүүргийн Засаг дарга нар- 7 шийдвэр
5. Сайд, Төрийн нарийн бичгийн дарга-3 шийдвэр
6. Газрын алба- 2 шийдвэр
7. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дарга -1 шийдвэр
8. Нийслэлийн хөдөө аж ахуйн газрын дарга-1 шийдвэрийг тус тус биелүүлэхгүй байна. Зураг 6



Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэхийн тулд шийдвэр гүйцэтгэгч Захиргааны албан тушаалтанд шийдвэр гаргахыг мэдэгдсэн **албан бичгийг удаа дараа явуулж**, олон удаа тухайн албан тушаалтантай болон хуулийн зөвлөхтэй уулзаж шүүхийн шийдвэрийг хэзээ биелүүлэхийг **асуухаас** өөрөөр ямар ч арга хэмжээ авч чаддаггүй байна.

Шүүхийн шийдвэр биелэхгүй байгаа шалтгаан, түүнчлэн шийдвэрийг



биелүүлэх явцад учирч буй хүндрэл бэрхшээлийг тогтоох зорилгоор Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны шийдвэр гүйцэтгэгч нартай ярилцлагын аргаар шүүхийн шийдвэр биелэгдээгүй шалтгааныг тодруулсан бөгөөд дараах хүндрэл бэрхшээлтэй тулгардаг байна. Үүнд:

1. Захиргааны байгууллага, албан тушаалтан нь шийдвэр гүйцэтгэгчийн шаардлагыг тоодоггүй, үл хэрэгсдэг.

2. Захиргааны шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх хуулийн зохицуулалт Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд байхгүйгээс шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг хэрхэн явуулах талаар шийдвэр гүйцэтгэгч нар нэгдсэн ойлголтгүй, шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явуулсан шийдвэр гүйцэтгэгч буруутгагддаг байна.

3. Шүүхийн шийдвэр ойлгомжгүй, хэрэгжих боломжгүй байдлаар гардаг.

4. Шүүхийн шийдвэрээр тогтоогдсон төрийн албан хаагчийг ажилд нь томилуулах гэтэл өөр хүн тухайн албан тушаалд ажиллаж байдаг.

5. Ажлаас үндэслэлгүй халагдсан төрийн албан хаагчид цалин гаргуулахаар Төрийн санд хандахад төсвийн ерөнхийлөн захирагчаас бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн цалинг олгоно гэдэг. Төсвийн ерөнхийлөн захирагч нь тухайн албан хаагчийг халсан захиргааны албан тушаалтан байдаг. Тухайн жилийн төсвөөс гаргуулах боломжгүй.

Захиргааны шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байгаа албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагыг тусгасан эрх зүйн зохицуулалт

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-т “Захиргааны хэргийн шүүхийн актыг биелүүлээгүй этгээдэд энэ хууль, Эрүүгийн хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль болон хууль тогтоомжийн бусад актад заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэж заасан байна.

Шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байгаа захиргааны байгууллагын албан тушаалтанд:

1. Захиргааны хариуцлагын тухай хууль

2. Эрүүгийн хуульд заасан арга хэмжээг авах хуулийн механизм байна.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг сайн дураараа биелүүлээгүй захиргааны байгууллага, албан тушаалтанд ногдуулах албадлагын арга хэмжээг Захиргааны хариуцлагын тухай хуулийн 30⁴ дугаар зүйлийн 3-т “Шийдвэр биелүүлэхээс санаатайгаар зайлсхийсэн...бол **5000-10000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.**” гэж заажээ.

Харин Эрүүгийн хуулийн 258 дугаар зүйлийн 258.1-д “Хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийтгэх тогтоол, шийдвэр, магадлал, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг санаатай биелүүлээгүй, эсхүл биелүүлэхэд нь зориуд саад учруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун тавин



цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.” гэж заасан байх бөгөөд энэ зүйлд заасан гэмт хэрэгт сэжигтнээр тооцогдсон, яллагдагчаар татагдсан, ял шийтгэгдсэн этгээд шүүхийн шийдвэрийг биелүүлсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө гэсэн *тайлбартай* байх юм.

Хууль бус шийдвэр гаргасан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын механизмыг бусад хуульд тусгасан байдал

Хууль бус шийдвэр гаргаж, иргэн, хуулийн этгээдийг хохироосон албан тушаалтанд түүний дээд шатны байгууллага, албан тушаалтан, эсхүл эрх бүхий өөр бусад байгууллагын албан тушаалтан арга хэмжээ авахаар зарим салбар хуулиудад зааж өгсөн байдаг байна. Үүнд:

- ❖ Төрийн албаны зөвлөл албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас төрд учруулсан хохирлыг арилгуулахаар төрийн нэрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.³⁷
- ❖ Шүүгч төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар ажлаас халсан албан тушаалтныг 45000-60000 төгрөгөөр торгох арга хэмжээ авахаар Төрийн албаны тухай хуульд тусгагджээ.³⁸
- ❖ Тухайн шатны Хурал нь Засаг дарга ... хууль тогтоомж зөрчсөн буюу чиг үүргээ хэрэгжүүлж чадаагүй бол түүнийг бүрэн эрхийнх нь хугацаа дуусахаас өмнө огцруулах саналыг дээд шатны Засаг дарга буюу Ерөнхий сайдад хүргүүлнэ.³⁹
- ❖ Төрийн албаны зөвлөл нь эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэхээргүй бол ерөнхий менежерийг албан тушаалаас чөлөөлөх тухай саналаа эрх бүхий байгууллагад тавих, ерөнхий менежерийн ажлыг дүгнэх, урамшуулахад зөрчлийг харгалзан үзэх, төсвийн байгууллагын ерөнхий менежерээс бусад албан тушаалтан хууль зөрчсөн бол түүнд арга хэмжээг авахуулахаар тухайн байгууллагын удирдлагад санал болгох эрх хэмжээтэй байна.⁴⁰
- ❖ Төсвийн ерөнхийлөн захирагч, ерөнхий менежер ажилтныг үндэслэлгүйгээр ажлаас халсан бол түүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх үндэслэл болдог байна.⁴¹

Захиргааны шүүхийн шийдвэрийг үр дүнтэй хэрэгжүүлэх механизмыг боловсронгуй болгоход дараах саналтай байна. Үүнд:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд “Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа” гэсэн бүлгийг нэмж оруулан шийдвэр гүйцэтгэх байгууллагаас захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг ямар

³⁷ Төрийн албаны тухай хуулийн 35.1.2

³⁸ Төрийн албаны тухай хуулийн 41.1.3

³⁹ Монгол улсын нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 32.2

⁴⁰ Төсвийн байгууллага удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 65.2

⁴¹ Төсвийн байгууллага удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 65.3



- хугацаанд, ямар арга, журмаар хэрхэн биелүүлэх, шийдвэр биелүүлэхгүй байгаа албан тушаалтанд авах хариуцлага зэрэг асуудлыг тусгаж өгсөн нэг бүлгийг нэмж оруулах
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцооны асуудлыг дахин авч үзэх
 3. Захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус шийдвэрийн улмаас хохирсон иргэн, хуулийн этгээдийн төлбөрийг Төрийн сангаас шууд гаргуулах зохицуулалтыг Төсвийн байгууллага, удирдлага, санхүүжилтийн тухай хуульд тусгаж өгөх
 4. Хууль бус шийдвэр гаргасан захиргааны албан тушаалтанд хүлээлгэх торгуулийн хэмжээг Захиргааны хариуцлагын тухай хуульд өөрчлөлт замаар нэмэгдүүлэх.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хараат бус, бие даасан зарчмаар ажиллаж, тэдгээрийн үйл ажиллагааг тодорхой заасан эрх зүйн орчинтой, тавьсан шаардлагыг биелүүлээгүй албан тушаалтанд ногдуулах хариуцлагын механизм өндөр, төрийн байгууллагатэй уялдаа холбоотой шуурхай ажиллаж чадвал Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр “цаас” биш, “шийдвэр” байж, иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хамгаалагдаж, улмаар захиргааны байгууллага, албан тушаалтнаас дахин хууль бус шийдвэр гарах явдал багасах үр нөлөөтэй гэсэн нэгдсэн дүгнэлтийг өгч байна.